



ПИКО ИНЖЕНЕРИНГ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.МӨНХЖАРГАЛД

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн газрын байр, 8 дугаар баг,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2496, Цахим шуудан: emg@khs.gov.mn
Цахим хуудас: khs.mohs.gov.mn

№ 10-33-02/124/112

Барилгын зураг төсөл хянасан
тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3. дахь “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна” гэсэн заалт, ЭМЯ-ны салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02 дугаартай удирдамжийг үндэслэн Пико инженеринг ХХК-ийн 2024 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 24/10 дугаартай хүсэлтийн дагуу Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны Урандеш хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ПИ.М-2024/19 шифрийн дугаартай ажлын зургийг эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Л.Нямгэрэл 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авч, хяналт хийв.

Хатгал тосгоны хүүхдийн цэцэрлэгт сумын засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/43 дугаартай шийдвэрийг үндэслэн Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 6-р багт 8097 м.кв талбай бүхий газрыг боловсролын байгууллагын зориулалтаар олгосон байна.

Барилгын зураг төсөл нь аймгийн ерөнхий архитектурын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн АТД-67-29/23 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, аймгийн засаг даргын орлогч даргын баталсан 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 2023-ЗД/71 дугаартай ажлын зураг төсөл боловсруулах даалгавраар батлагдсан байна. 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн № 023 дугаартай Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны “Уран дөш” хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлын зураг төсөв, зөвлөх үйлчилгээ худалдан авах гэрээг захиалагчаар Хатгал тосгоны захирагч гүйцэтгэгчээр Пико инженеринг ХХК-ийн захирал нар хийсэн байна. Цахилгаан эрчим хүчээр хангах 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 78/2024 дугаартай техникийн нөхцөл олгогдсон байна.

Барилгын инженер геологийн “Хангайн Инж Гео” ХХК-ийн 14/24 дугаартай Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын 6 дугаар багт байрлах Хатгал тосгоны “Уран дөш” хүүхдийн цэцэрлэгийн 100 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга баригдах талбайд 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийсэн геологийн судалгааны дүгнэлтээр 8.0-10.0 метрийн гүнтэй 2 ширхэг цооног ерөмдөхөд хөрсний ус илрээгүй, тухайн нутаг дэвсгэр нь олон жилийн цэвдэг хөрс үргэлжилсэн тархалттай бүсэд

хамрах ба олон жилийн цэвдгийн дээд хил улирлын хөлдөлт гэсэлтийн гүнтэй нийлэх зэргээс инженер-геологийн төвөгтэй нөхцөлтэй ба газар хөдлөлтийн 8 баллын бүсэд хамаарна гэсэн байна.

Барилга нь тэнхлэгээрээ 24 х 24.4 м хэмжээтэй, метал черепизен дээвэртэй, төмөр бетон араг бүтээцтэй, нийт 470.0 м² талбайтай 2 давхар байхаар төлөвлөгдсөн байна. Барилгын нэгдүгээр давхарт тус бүр 30-36.87 м.кв унтлагын өрөө, 11.01 м.кв ариун цэврийн өрөө, 8.93 м.кв хувцас солих өрөөтэй 64.82-91.11 м.кв бүлгийн 2 өрөө, 38.23 м.кв гал тогоо, 14.81 м.кв хоол бэлтгэх өрөө, 5.33 м.кв хүйтэн агуулах, 6.86 м.кв хуурай агуулах, 6.66 м.кв бохир угаах хэсэг, 11.02 м.кв гал тогооны ажилчдын ариун цэврийн өрөө, 7.07 м.кв ажилчдын хувцас солих өрөө, 9.54 м.кв агуулах, цахилгааны өрөө, узелгийн өрөө, хонгил, хоёрдугаар давхарт тус бүр 30-36.87 м.кв унтлагын өрөө, 11.01 м.кв ариун цэврийн өрөө, 8.93 м.кв хувцас солих өрөөтэй 64.82-91.11 м.кв бүлгийн 2 өрөө, 33.73 м.кв дуу хөгжмийн танхим, 8.30 м.кв ажилчдын ариун цэврийн өрөө, 15.88 м.кв хурлын өрөө, 24.51 м.кв эрхлэгчийн өрөө, 35.0 м.кв нярвын өрөө, 22.30 м.кв багш хөгжлийн өрөө, хонгил, шат зэргийг зураг төсөлд төлөвлөсөн байна.

Барилгын халаалтын эх үүсвэрийг халаалтын цахилгаан тогооноос хангахаар төлөвлөсөн. Халаалтын систем нь доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал эргэлттэй усан халаалтын систем байх ба нэгдүгээр давхрын бүлгийн өрөө, унтлагын өрөө, хуцас солих өрөөнүүдэд дулаан алдагдлын 20%-д шалны халаалт төлөвлөсөн байна.

Барилгын гал тогооны хэсэг, бүлгийн ба унтлагын өрөө, ариун цэврийн өрөөнүүд болон ажилчдын өрөөнд агаар соруулах механик систем төлөвлөсөн байна.

Усан хангамжийн эх үүсвэр нь зөөврөөр хангагдахаар төлөвлөгдсөн. Одоо байгаа барилгын техникийн өрөөнд байрлах 30 м³ цэвэр усны нөөцийн сав, хэрэглээний халуун ус халаах 1 м³ цахилгаан ус халаагч зэргээс ахуйн цэвэр, халуун усны хэрэглээг хангахаар зураг төсөлд тусгасан байна. Бохир ус нь ф50 – ф100-ийн голчтой, 0.002 налуутай PVC-U хуванцар хоолойгоор барилгаас өөрийн урсгалаар зайлуулагдахаар төлөвлөсөн байна.


Зураг төслийг хянаад ДҮГНЭХ НЬ:

1. Барилгын дотоод засалд эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан, шинжилгээний дүн, сертификацтай барилгын материалыг ашиглах нь зүйтэй.
2. Пико инженеринг ХХК-тай хийсэн ажлын зураг төсөв, зөвлөх үйлчилгээ худалдан авах гэрээнд тусгагдаагүй учраас гадна инженерийн шугам, сүлжээний ажлын зураг төсөл хийгдээгүй байна. Гадна инженерийн шугам, сүлжээний ажлын зураг төслийг хийлгэж холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хянуулах шаардлагатай.
3. Барилгын ажлын зураг нь Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга БНБД 31-24-22 норм, дүрмийн эрүүл ахуйн заалтын шаардлагыг хангаж байна.

4. Улсын байцаагчийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.



ДУГНЭЛТ БИЧСЭН
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Л. НЯМГЭРЭЛ


.....

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН: